



X/2021

Тархаасан: 2021 оны 11 дүгээр сарын 15




Нас гүйцсэн эр хонины үнэ Улаанбаатар хотод хамгийн өндөр буюу 280.0 мянган төгрөг байна

Малын зах зээлийн дундаж үнийн мэдээллээр 2021 оны 10 дугаар сард атны үнэ 1.3 сая төгрөг болж, өмнөх сараас 50.6 мянган төгрөгөөр, хязаалан гунынх 1.3 сая төгрөг болж, өмнөх сараас 45.8 мянган төгрөгөөр, соёолон үрээнийх 1.1 сая төгрөг болж, өмнөх сараас 24.4 мянган төгрөгөөр тус тус өссөн байна.


Эр хонины үнэ 206.9 мянган төгрөг болж, өмнөх сараас 2.3 мянган төгрөгөөр, эр ямааны үнэ 144.6 мянган төгрөг болж, өмнөх сараас 400 төгрөгөөр тус тус буурсан байна.

ЗУРАГ 1. НАС ГҮЙЦСЭН МАЛЫН ДУНДАЖ ҮНЭ(сум), 2021 оны 10 дугаар сард, мянган төгрөгөөр




Эр хонь 2021 оны 10 дугаар сард Улаанбаатар хотод хамгийн их буюу 280.0 мянган төгрөг болж, өмнөх сараас 20.0 мянган төгрөгөөр буурч, Дорнод аймагт хамгийн бага буюу 164.3 мянган төгрөг болж, өмнөх сараас 7.2 мянган төгрөгөөр өссөн байна.

ЗУРАГ 2. НАС ГҮЙЦСЭН ЭР ХОНИНЫ ДУНДАЖ ҮНЭ, 2021 оны 10 дугаар сард, мянган төгрөгөөр




Газар тариалангийн бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнийн мэдээллээр 2021 оны 10 дугаар сард боодолтой өвсний (20кг) үнэ Говь-Алтай аймагт хамгийн их буюу 13.2 мянган төгрөг, Сэлэнгэ аймагт хамгийн бага буюу 4.1 мянган төгрөг байна.

ЗУРАГ 3. БООДОЛТОЙ ӨВСНИЙ ДУНДАЖ ҮНЭ, 2021 оны 10 дугаар сард, төгрөг



Үхрийн 2 метрээс дээш урттай шир 2021 оны 10 дугаар сард 7.0 мянган төгрөг болж, өмнөх сараас 400 төгрөгөөр буурч, ямааны цагаан ноолуур 1 кг-ын үнэ 110.1 мянган төгрөг болж, өмнөх сараас 11.8 мянган төгрөгөөр өссөн байна.

ЗУРАГ 4. МАЛ АЖ АХУЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЗАХ ЗЭЭЛИЙН ДУНДАЖ ҮНЭ, жил бүрийн 10 дугаар сард, төгрөг



Хивэгний 25 кг үнэ 2021 оны 10 дугаар сард Хэнтий аймагт хамгийн их буюу 24.0 мянган төгрөг, Архангай аймагт хамгийн бага буюу 15.0 мянган төгрөг байна.

Тооцох аргачлал:

Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнийн судалгааг сар бүр, сум, дүүрэг, аймаг, нийслэлийн худалдааны цэгүүдээс авч нэгтгэн сарын дундаж үнийг арифметик дунджаар тооцно.



Эх үүсвэр:

ҮСХ, ХАА-н бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнийн мэдээ

Мэдээлэл авах холбоос:

<http://www.nso.mn/>

<http://www.1212.mn/>

Дараагийн мэдээ тархаах хуваарь:

2021 оны 12 дугаар сарын 15

Эдийн засгийн статистикийн газрын дарга

А.Дэмбэрэл

Утас : (976-51)-329272

Эдийн засгийн статистикийн газрын Үнийн

статистикийн хэлтсийн гэрээт ажилтан Б.

Оргил

Утас : (976-51)-261563



/StatisticMGL



information@nso.mn



1900-1212